

## САНАЛ, ЗӨВЛӨМЖ ХҮРГҮҮЛЭХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газар нь Швейцарын хөгжлийн агентлагтай хамтран хэрэгжүүлж байгаа “Нутгийн өөрөө удирдах байгууллагын институцийн чадавхыг бэхжүүлэх” төслийн нэг зорилго нь иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас батлан гаргах журам, зохицуулалтыг Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай болон холбогдох бусад хуультай нийцүүлэн боловсруулахад дэмжлэг үзүүлэх явдал билээ.

Төслийн уг зорилгын үүднээс, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас боловсруулан баталж, улсын нэгдсэн санд бүртгүүлэхээр хүргүүлж байгаа захиргааны актын боловсруулалтад гарч байгаа нийтлэг алдаа дутагдал, засч сайжруулах болон анхаарах зүйлсийн талаар тодорхой зөвлөгөө санал ирүүлэх тухай албан бичгийг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсний дагуу тус яамны Төрийн нарийн бичгийн даргаас ирүүлсэн санал, зөвлөмжийг Та бүхэнд танилцуулж байна.

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, төлөөлөгч, нарийн бичгийн дарга, Ажлын албаны албан хаагчид Та бүхэн хэм хэмжээ тогтоосон аливаа шийдвэрийн төсөл боловсруулахдаа энэхүү санал, зөвлөмжийг анхааран үзнэ үү.

Төслийн нэгж